



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.04

№ ХЭ2020003

Улаанбаатар хот

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сунгах, шинээр томилгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 4 сарын 04-ны өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, Тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйл 77.1; 62 дугаар зүйл, 62.1.7 дахь заалт, Компанийн дүрмийн 7.7.5 дахь заалтыг тус тус удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналыг авсан нэр бүхий 9 гишүүний бүрэн эрхийг хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурал хуралдах хүртэл хугацаагаар сунгасугай.

ТУЗ-ийн ердийн гишүүн

- Сандагийн Балжинням
- Сандагийн Баянчулуун
- Сандагийн Баянмөнх
- Маамуугийн Нямдаваа
- Цэндсүрэнгийн Ганшэцэг
- Норовын Энхцэцэг

Хараат бус гишүүн

- Ганболдын Сономжамц
- Баярдалайн Бат-Ирээдүй
- Тунгалагийн Мөнгөнцацрал

ХОЁР. ТУЗ-ийн гишүүнээр улиран сонгогдсон гишүүдэд баяр хүргэж, Компанийн засаглалын зарчмыг баримтлан ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОГТООЛ

2020.04.04

№ ХЭ2020002

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааны тайланг дүгнэх тухай

Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 сарын 04-ний өдрийн ээлжит хуралдааны шийдвэрийг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. ТУЗ-ийн гишүүдийн 2019 оны үйл ажиллагааны тайланг үндэслэлтэйд тооцон, зөв гэж үзсүгэй.

ХОЁР. ТУЗ-ийн 2019 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.04

№ ХЭ2020001

Улаанбаатар хот

2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ДҮГНЭЛТ БАТЛАХ ТУХАЙ

Алтайн Зам ХК-ийн 2020 оны 4 сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, тооллогын комиссын 001 тоот тогтоолыг үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл, 62.1.9 дэх заалтыг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

НЭГ. Компанийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагааны тайлангийн дүгнэлттэй танилцан Леон Аудат ХХК-ийн гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, ТУЗ-ийн танилцуулсан дүгнэлтийг баталсугай.

ХОЁР. 2020 онд үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахыг ТУЗ-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



М.НЯМДАВАА



“АЛТАЙН ЗАМ” ХК ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020.04.04

№ ХЭ2020004

Улаанбаатар хот

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ НЭМЖ, ДҮРЭМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

“Алтайн Зам” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 04 сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, санал хураалтын дүнг тус тус үндэслэн, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийг удирдлага болгон **ТОГТООХ** нь:

1. Компанийн үйл ажиллагааны чиглэлд авто машинаар ачаа тээвэрлэх үйл ажиллагааг нэмсүгэй.

2. Үйл ажиллагааны чиглэл нэмэгдэж байгаагай холбогдуулан дүрмийг тогтоолын хавсралт №1-д зааснаар баталсугай.

3. Алтайн Зам ХК-ийн үйл ажиллагааны нэмэлт чиглэл болон шинэчилсэн дүрмийг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газарт хандан бүртгүүлж албажуулахыг Гүйцэтгэх удирдлагын багт даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ
НЬЮПРОГРЕСС ГРУПП ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ

ХУРЛЫН ДАРГА



С.БАЛЖИННЯМ

М.НЯМДАВАА